



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 02 сарын 07 өдөр

Дугаар А/67

Хэрлэн сум

Хурдан морины уралдаан зохион
байгуулахыг хориглох тухай


Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, 60 дугаар зүйлийн 60.1.1, Хүүхдийн эрхийн тухай хуулийн 17 дугаар зүйлийн 17.1.2 дахь заалт, Засгийн газрын 2019 оны 01 дүгээр сарын 30-ны өдрийн 57 дугаар тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Аймгийн нутаг дэвсгэрийн хэмжээнд бооцоот болон хурдан морины уралдаан, сунгаан, үсэргээ, зохион байгуулахыг 2024 оны 05 дугаар сарын 01-ний өдрийг хүртэлх хугацаанд хориглосугай.

2. Дурдсан хугацаанд бооцоот болон хурдан морины уралдаан, сунгаан, үсэргээ зохион байгуулахгүй байхыг иргэд, нийт уяачдад сурталчлан таниулах ажлыг зохион байгуулахыг Цагдаагийн газар (Э.Жавхлантөгс), Хүүхэд, Гэр бүлийн хөгжил, хамгааллын газар (Х.Уртнасан), "Сэцэн ханы хүлэг" уяачдын холбоонд тус тус үүрэг болгосугай.

3. Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга нар, хяналт тавьж ажиллахыг Цагдаагийн газрын дарга (Э.Жавхлантөгс), Хүүхэд, Гэр бүлийн хөгжил, хамгааллын газар (Х.Уртнасан)-т тус тус үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ц.ЧОГСОМЖАВ